



# ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА

ЛАВЛАХ УТАС:  
**7019-1065**



**1**

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын захиалгаар 2024-2025 оны хичээлийн жилд Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа

- Москва хотын их сургуулийн **"МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ"**,
- Волгоград хотын академийн **"ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ"**,
- Екатеринбург хотын Уралын хууль зүйн дээд сургуулийн **"ЭРХ ЗҮЙ"**-н бакалаврын хөтөлбөр, Удирдлагын академийн магистр, адъюнктурт элсүүлэн суралцуулах сонгон шалгаруулалтыг зарлаж байна.



**3**

**БАКАЛАВРТ /БЭЛТГЭЛ/  
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

## 1. АЛБА ХААГЧДАД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

- Захиалагч байгууллагад 3-аас доошгүй жил А, В буюу түүнтэй тэнцэх үнэлгээтэй ажилласан байх;
- Албаны сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй байх.

**4**

**МАГИСТРАНТУРТ  
ТАВИГДАХ ШААРДЛАГА**



- Бакалаврын боловсролтой, захиалагч байгууллагад мэргэжлээрээ ахлах мэргэжилтэн, түүнээс дээш зэрэглэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа;
- Орос хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй;
- Эрүүл мэндийн хувьд архаг өвчин, сэтгэцийн эмгэггүй;
- Албаны сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй байх.



**6**

**БҮРДҮҮЛЭХ  
МАТЕРИАЛ**

- Иргэний үнэмлэх нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Боловсролын гэрчилгээ, диплом эх хувиараа болон нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Албан хаагчид ажлын газрын тодорхойлолт;
- Иргэний ял шийтгэлтэй эсэх талаар лавлагаа;
- Одоо суралцаж буй оюутан бол сургуулийн тодорхойлолт, сургалтын голч дүнгийн хуулбар;



**2**

**ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ  
НИЙТЛЭГ ШААРДЛАГА**

- Орос хэлний мэдлэгтэй;
- Бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэндийн зохих шалгуурыг хангасан байх;
- Ял шийтгэлгүй;
- 17-25 хүртэл насны иргэн, сонсогч;
- 28 хүртэлх насны алба хаагч.

## 2. ИРГЭДЭД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

- Бүрэн дунд боловсролтой, ерөнхий боловсролын сургуулийг А, В үнэлгээтэй суралцаж төгссөн, төгсөж байгаа эсхүл магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 1-2 дугаар дамжаанд 3.4-өөс дээш голч дүнтэй суралцаж байгаа.

**5**

**АДЪЮНКТУРТ ТАВИГДАХ  
ШААРДЛАГА**



- Магистрын боловсролтой, мэргэжлээрээ захиалагч байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа;
- Зэрэг горилох чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж, бүтээлээ мэргэжлийн сэтгүүлд эсхүл ном товхимол болгон нийтлүүлсэн;
- Элсэгчийн судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, агуулга нь харьяа байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон;
- Орос хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй;
- Эрүүл мэндийн хувьд архаг өвчин, сэтгэцийн эмгэггүй;
- Албаны сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй байх.

**10**

**7**

**БҮРТГЭЛ**

- Бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлт гаргасан алба хаагч, иргэдээс Орос, Монгол хэл, бие бялдар, сэтгэл зүйн сорилын шалгалт, ярилцлага авна;